





**ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
<p>Зорилго: Салбар дундын оролцоонд тулгуурласан настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй, чанартай, хүртээмжтэй хүргэхэд оршино.</p>						
<p>Зорилт 1. Ахмад настныг насжилтаас үүдэлтэй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлнэ.</p>						
БСТ	1. Ахмад настанд зориулсан эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөллийг тасралтгүй зохион байгуулна.	Улсын хэмжээнд 2024 онд нийт настнуудын 8.2 хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна.	Улсын хэмжээний ахмад настнуудын 8.8 хувь нь хамрагдсан байна.	I-IV улирал	"Эрүүл насжилтын төлөө хамтдаа" уриан дор 2025 онд ахмад настнууд болон иргэд олон нийтэд зориулсан сургалт сурталчилгааны мэдээллийг Геронтологийн үндэсний төв, аймаг орон нутаг, нийслэл дүүргийн ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд цахим болон танхимын сургалт, өдөрлөг зэрэг олон хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулна. Хөдөө орон нутгаас 3 аймаг / Дундговь, Хөвсгөл, Дорноговь/, дүүргүүдээс Чингэлтэй, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн тайланг нэгтгэлээ. Үүнд: Танхимын сургалтаар 11563, цахимаар 44864 ахмадад сургалт зохион байгуулсан ба ахмадын сарын аян, эрүүл идэвхитэй насжилтыг сурталчилсан зурагт хуудас, мэдээллийг Геронтологийн үндэсний төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, орон нутгийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсаар олон нийтэд түгээснийг 5100 хандалт, 1136 хүн хуваалцсан байна. Нийт давхардсан тоогоор 15.75% буюу 62663 ахмад настанд мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулсан.	100%
						

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 1.1.1. 2	2. Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна.	Булган, Өвөрхангай аймаг, Нийслэлийн 6 дүүрэг, хороо, сум тосгоны 1903 ахмад настан хамруулсан байна.	6-аас доошгүй алслагдсан хороо, дүүргийн 2000 ахмад настан хамруулна.	I-IV улирал	<p>Урьдчилан сэргийлэх үзлэг: Орон нутагт:</p> <ul style="list-style-type: none"> • Сэлэнгэ аймгийн Мандал сум • Бага-хангай дүүргийн ахмадын хороо <p>Нийслэлд:</p> <ul style="list-style-type: none"> • ЧД -ийн 12, 22, 16 дугаар хороод • СХД -ийн 01, 03, 06, 07, 14, 16, 17, 22, 23, 27, 30, 31, 32, 41/ дугаар хороод • БЗД -ийн 08, 09, 16, 18, 19, 31, 32 дугаар хороод • ХУД -ийн 02, 09, 07, 11, 22 дугаар хороод • БГД -ийн 04, 26 дугаар хороод <p>Нийт 33 хорооны 2,015 ахмад настанг урьдчилан сэргийлэх үзлэг болон шаардлагатай оношилгоо, шинжилгээнд хамруулсан.</p>	100%
						

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилготой түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 1.1.1. 3	3. Ахмадын эрүүл мэндийг сарын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулна.	Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд 4-5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 20000 гаруй ахмад настныг хамруулсан.	Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд 5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 20000 гаруй ахмад настныг хамруулсан байна.	IV улирал	<p>Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд: Дараах ажлуудыг зохион байгуулав.</p> <p>I. "Эрүүл идэвхитэй насжилт - 2025" үндэсний зөвлөгөөн:</p> <p>2025 оны 10-р сарын 6-ны өдөр ЭМЯ-тай хамтран "Эрүүл идэвхитэй насжилт - 2025" үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулж, ГБХНХЯ, Хүний эрхийн үндэсний комисс, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл, АШУУИС зэрэг 70 гаруй төлөөлөл оролцон ахмад настны тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, эрүүл насжилтийг дэмжих цаашдын үйл ажиллагааны хэтийн төлвийг хэлэлцэн, Зөвлөмж гаргалаа.</p>  <p>II. Хамтарсан тушаал: 2025 оны 10 дугаар сард 03-ны өдөр Эрүүл мэн, Хөдөлмөр нийгмийн сайдын хамтарсан А366, А191-р тушаалаар "Эрүүл настан, идэвхитэй насжилтыг дэмжих 2025-2028 оны арга хэмжээний төлөвлөгөө" батлагдлаа.</p> <p>III. "ЭРҮҮЛ ИДЭВХТЭЙ НАСЖИЛТ-2025" Эрдэм шинжилгээний бага хурал 2025 оны 10 дугаар сарын 7-нд зохион байгуулсан. /2.2.1.1-ын 27-д дэлгэрэнгүй бий/</p>	100%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					 <p>IV. Аэробик дасгалын тэмцээн: 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Геронтологийн үндэсний төвөөс Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/173 тушаалыг хэрэгжүүлэх, хүн амыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгоход уриалах зорилгоор Нийслэлийн ахмадын хороотой хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд явган алхалт, "Жавхаат хэмнэл" аэробик дасгалын тэмцээнийг нийслэлийн 7 дүүргийн ахмадуудын төлөөллийг оролцуулан зохион байгууллаа.</p> <p>Уг өдөрлөгт Геронтологийн үндэсний төвийн эмч, ажилтнууд, Баянзүрх, Баянгол, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдийн ахмадын төлөөлөл, Геронтологийн үндэсний төвийн эмч, эмнэлгийн ажилчид нийт 150 гаруй ахмад настууд оролцлоо. "Жавхаат хэмнэл" аэробик дасгалын тэмцээнд Хан-Уул, Баянгол, Налайх дүүргийн багуудыг амжилттай оролцсынг Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.</p> <p>V. Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд: Монгол Улсад "Ахмад настны тухай" хуульд тусгасны дагуу "Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сар"-ын хүрээнд Геронтологийн үндэсний төвөөс аймаг, дүүргийн ЗДТГазарт "Эрүүл идэвхтэй насжилтыг"</p>	






Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
1	4. Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сүлжээ бий болгож, олон нийтийн оролцоог хангана. БСТ 1.1.2.1 4. Ахмадын ЭМ-ийг дэмжих чиглэлээр ажилладаг ТББ-ын туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	2024 онд идэвхтэй насжилтыг дэмждэг сайн дурын 12 төрийн бус байгууллага, 40 хүнийг хамруулсан уулзалт зохион байгуулж, туршлага солилцсон.	15 төрийн бус байгууллага, 50 хүнийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, оролцогч талуудын оролцоог хангасан байна.	I-IV улирал	дэмжб" уриалгыг хургуулж хамтран ажилласан ба 21 аймгаас 17 аймаг, 5 дүүргээс тайлангаа ирүүлсэн нийт давхардсан тоогоор 150,000 орчим ахмад настанд сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үзлэг, гэрийн тусламж үйлчилгээ зэргийг үзүүлсэн байна.	90%




Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
	<p>чиглэлээр анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.</p>				<p>үнэлгээний хяналтыг хөдөө орон нутгийн 6 сумын ЭМТөв, 2 өрхийн ЭМТөв, нийслэлийн 12 өрхийн эрүүл мэндийн төв /ЧД-3, ХУД-3, СБД-3, БН-2, БХ-1/ нийт 20 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийж арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Хяналтаар ахмад настны цогц үнэлгээ хийх бэлтгэлийг нийт байгууллагын 55% нь хангасан, анхан шатны ЭМБ-ын удирдлагын дэмжлэг зарим байгууллагуудад хангалттай биш, сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтэн дотооддоо сургалт хийж арга зүйгээр хангаагүй зэрэг тулгамдсан асуудлууд илэрсэн. Мөн анхан шатны ЭМБ-уудын цахим бүртгэлд настны цогц үнэлгээний асуумж дүгнэлт ороогүйгээс цаасаар бүртгэлийг давхар компьютерт мэдээллийг шивж оруулдаг.</p>	100%
БСТ 1.1.2. 4	<p>7. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/23 дугаар тушаал "Гериатрийн кабинетийн үлгэрчилсэн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.</p>	<p>8 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p>	<p>10 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.</p>	<p>I-IV улирал</p>	<p>Геронтологийн үндэсний төвийн захирлаар батлуулсан "Гериатрын кабинетын үлгэрчилсэн дүрэм-ийн" хэрэгжилтийг хангах удирдамжийн дагуу Орон нутагт 7 аймаг /Өвөрхангай, Говь Алтай, Баянхонгор, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, Ховд/, Нийслэлийн 3 дүүрэгт /Багахангай, Багануур, Сүхбаатар / -ийн ДЭМТ, ДНЭ, БОЭТ-ийн ахмадын кабинетүүдэд дэмжлэгт хяналт хийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Дэмжлэгт хяналтаар ахмадын кабинетын үлгэрчилсэн дүрмийн хэрэгжилт хангалттай биш, гериатрийн мэргэшсэн эмч, сувилагч орон тоогоор ажилладаггүй, мэдээллийн систем /Багануур, хавсарч хийдэг асуудлууд тулгамдаж байна. Цаашид гериатрын эмчийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг тодорхой болгох ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.</p> <p>Нийт 10 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>	100%




Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
						
Зорилт 3. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлнэ. (ЗГУАМХ)						
БСТ 1.1.3.1	Геронтологийн үндэсний гамшигас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулан хэрэгжүүлнэ.	2024 онд Гамшигас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол бэлэн хангаж ажилласан.	Гамшигас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангаж, дадлага сургуулийг 2 удаа хийсэн байна.	I-IV улирал	Гамшигас хамгаалах төлөвлөгөө: • Гамшигас хамгаалах төлөвлөгөө -нд 2025 оны 11 дүгээр сарын 25 -ны өдөр СБД -ийн Онцгой байдлын хэлтсийн орлогч даргад хянуулан тодотгол хийсэн. Дадлага, сургуулилт: 1. ЭМЯ, Дэлхийн банк -наас хамтран 2025 оны 05 дугаар сарын 08 -ны өдөр ЗӨСҮТөвд зохион байгуулагдсан "Гамшгийн үед хариу арга хэмжээ үзүүлэх танхимын болон дадлага сургуулилт" сургалтад 2 эмч, мэргэжилтэн хамрагдсан. 2. "Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдал" -ын дадлага сургуулийг 2025 оны 03 дугаар сарын 27 - ны өдөр зохион байгуулсан.	100%
						

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					 <p>3. СБД -ын Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах 34 дүгээр ангийн сургагч багш А.Амарбаясгалан 2025 оны 11 дүгээр 28 -ны өдөр "Гал түймэрээс урьдчилан сэргийлэх нь" сургалт зохион байгуулсан 28 ажилтан хамрагдсан.</p> <p>Бусад ажлууд:</p> <ol style="list-style-type: none"> "Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө" -г Гал түймрийн улсын байцаагчаар хянуулж Геронтологийн Үндэсний төвийн захирал, Гал түймэр унтраах 34 дүгээр ангийн захирагч нараар тус тус батлуулсан. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардалд 2026 оны төсөвт 3.500.000 төгрөгийг тусгасан. 	
Зорилт 4. Настны цогц тусламж, үйлчилгээг хөгжүүлэн, нутагшуулна.	1. Ахмад настны тусламж үйлчилгээний заавар, журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	ЭМС 2024 оны 01 сарын А/22 дугаар тушаалаар "Ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар" батлагдсан, 2025 оны 01 сард ГБХНХ -ын сайд, ЭМС А/76, А/515 дугаар тушаалаар Ахмад настны цогц үнэлгээ хий, тусламж, үйлчилгээ	Геронтологийн үндэсний төвөөр 1000 ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.	I-IV улирал	<p>"Ахмад настны хам шинжийн илрүүлэх SCORE асуумж" үнэлгээгээр 2025 оны байдлаар амбулатороор нийт 2110 настан үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлсэн.</p> <ol style="list-style-type: none"> I түвшин 1600 буюу 79% нь эрүүл идэвхтэй ахмад настан. II түвшин 402 - 19.05% нь бага зэргийн тусламж үйлчилгээ шаардлагатай ахмад настан. III түвшин 108 - 5.118% нь тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай ахмад настныг хяналтад авсан. Үүнээс II, III түвшний 426 ахмад настныг лавшруулан үнэлж "Эрүүл идэвхтэй насжилтын төлөвлөгөө -г өгч ажилласан." 	75%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
		<p>үзүүлэх журам батлагдсан.</p>			<p>1. Танин мэдэхүйн чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Хэвийн 311 - 73% • Үл мэдэг буурсан 93 - 22% • Хүнд хэлбэрээр буурсан 22 - 5% <p>2. Хөдөлгөөний чадвар бууралт</p> <ul style="list-style-type: none"> • Хэвийн 63 - 15% • Бууралттай 363 - 85% <p>3. Хоол тэжээлийн доройтол</p> <ul style="list-style-type: none"> • Хэвийн 252 - 59% • Доройтол үүсэх эрсдэлтэй 153 - 36% <p>4. Доройтолтой 21</p> <ul style="list-style-type: none"> • Харааны бэрхшээл • Харааны бэрхшээлгүй 68 - 16% • Харааны бэрхшээлтэй 357 - 84% <p>5. Сонгол бууралт</p> <ul style="list-style-type: none"> • Сонголын бэрхшээлгүй 98 - 23% • Сонголын бэрхшээлтэй 328 - 77% <p>6. Сэтгэл гутрал</p> <ul style="list-style-type: none"> • Сэтгэл гутралгүй 340 - 80% • Сэтгэл гутралтай 85 - 20% 	
БСТ 1.2.1. 2	<p>2. Ахмад настны сэргэн засах эмчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Сэргэн засах, хөдөлмөрийн заслын тоног төхөөрөмжөөр хангасан.</p>	<p>Сэргэн засах эмчилгээний тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан байна.</p>	<p>IV улирал</p>	<p>2025 онд сэргэн засахын өдрийн эмчилгээнд шаардлагатай байгаа 2 нэр төлийн 61,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмжийг худалдан авч эмчилгээнд хэрэглэж байна.</p>  <p>1. Bio Tron-DX тенсiст аппарат /булчин сулруулах / Булчин сулруулах аппаратаар жилийн хугацаанд 350 настанд үйлчилгээ үзүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн.</p>	<p>90%</p>


Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 1.2.1.3	3. Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний заавар, журам боловсруулна.	ЭМС-ын 2022 оны 10 сарын 1-ний А/511 тушаалаар "Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулах" ажлын хэсэгт 2 мэргэжилтэн орсон.	Урт тусламж, үйлчилгээний загварыг боловсруулахад чиг үүргийн хүрээнд оролцсон байна.	I-IV улирал	Эмчилгээний үр дүн, хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байна. 2. STL-101 лазер эмчилгээний аппарат /үрэвсэл намдаах, яс ургалт зогсоох/ Худалдан авалтыг хийж хэрэглэхэд бэлэн болсон байна. Стандартын шаардлага хангасан өрөө тасалгааны хүрэлцээгүй байдлаас шалтгаалан ашиглаагүй байна.	100%
БСТ 1.2.1.4	4. Ахмад настанд амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	2024 онд 28641 ахмад настанд амбулаториор эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан байна.	Амбулаторийн тусламж, үйлчилгээг 29000 хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 750 ахмад настанд үзүүлсэн байна.	I-IV улирал	<ul style="list-style-type: none"> Амбулаторийн тусламж үйлчилгээг 35150 ахмад настанд үзүүлсэн. Өдрийн эмчилгээнд нийт 443 ахмад настанг хамруулан ажилласан байна. Шинэ эмнэлгийн барилга ашиглалтанд ороогүйтэй холбоотой хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлээгүй. 	100%
Зорилт 5. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.	2024 онд Төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт 92.5 хувьтай хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт 98.5 хувьтай хэрэгжсэн байна.	I-IV улирал	<p>1. Чанарын алба нь төлөвлөсөн хуваарийн дагуу чанарын хяналт үнэлгээг хийдэг. 2025 онд үндсэн 2 чиглэлд нийт 78 удаа хяналт хийхэд 96 хувьтай. Хяналтын үр дүнд дүгнэлт хийж ажилласан. ЭМТҮЧАБА 2025 онд 10 зорилтын хүрээнд 46 үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилт 97.8 хувь байна. Өмнөх оноос 4.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>2. Чанарын хяналт үнэлгээнд тусламж, үйлчилгээний чиглэлээр боловсруулсан 48 төрлийн хяналтын хуудаснуудыг ашиглаж байна.</p> <p>3. Чанарын албаанаас хийсэн хяналт үнэлгээний тайлантай.</p>	99.3%


Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 1.2.3. 2	6. "MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" стандарт, Геронтологийн үндэсний төвийн нийтлэг үйлчилгээний журмын хэрэгжилт хэрэгжилтийг хангаж ажиллана.	Геронтологийн үндэсний төвийн нийтлэг үйлчилгээний журмын хэрэгжилт 92.5 хувьтай байна.	Геронтологийн үндэсний төвийн нийтлэг үйлчилгээний журмын хэрэгжилт 93.5 хувьтай болсон байна.	I-IV улирал	<p>4. Чанарын хяналт үнэлгээний дүгнэлтэд үндэслэн 14 ажлыг сайжруулах талаар зөвлөмж, шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтэд эргэн хяналт тавьсан.</p> <p>Удирдлагын зөвлөлийн хурлаар эмийн хяналтын талаар 2 удаа, магадлангийн явцын талаар 2 удаа танилцуулж, хугацаа дууссан эм, эмийн хадгалалт, магадлангийн өөрийн үнэлгээний явц, магадланд шаардлагатай зүйлс, тулгамдаж буй асуудлуудыг танилцуулан шийдвэрлүүлж ажилласан. Мөн ЭМТҮЧАБА-аас эмнэлгийн 14 өрөөнд урсгал засвар хийх шаардлагатай байгааг удирдлагын зөвлөлд танилцуулж эхний ээлжинд эмнэлгийн 2 өрөөнд засвар үйлчилгээ хийж ажлын байрны нөхцөлийг сайжруулсан байна.</p> <p>1."MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага, стандарт"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд "Геронтологийн үндэсний төвийн эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах журам" төвийн захирлын 2023 оны А/104 дугаар тушаалаар батлагдсан журмыг төвийн ажилтнуудад танилцуулж хэрэгжилтэд 2 удаа хяналт үнэлгээ хийсэн. Хяналтыг 2025 оны 1 сар болон 9 сард эмнэлгийн 20 эмч, сувилагчийг хамруулан хийсэн, хяналтын дундаж хувь 94%. Хяналтаар илэрсэн дутагдалтай тал нь нэг өрөөнд 2 эмч суудаг учраас үйлчлүүлэгчийн нууц задрах, зовууриа гүйцэт хэлэхгүй байх зэрэг тал ажиглагдсан. Сайжруулах нийтлэг тал нь өрөөний хүртээмж хуваарилалтыг сайжруулвал уламжлалт, сэргээн засах эмчилгээнд шинэ нэр төрлийн тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх боломж гарна. Хяналтын дагуу эмч сувилагч нарт дотоод сургалт орж мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн.</p> <p>2. Үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөх лавлагаа мэдээллийн хөтөч нь утгах үйлчилгээний хэсэгт "Үйлчилгээний нийтлэг журам"-ын дагуу мэдээллийг өгч ажиллаж байна.</p>	100%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					<p>2. Амбулаторийн тусламж, үйлчилгээний үйл явц, дуугүй хөтөч болон зурагт хуудас, цахим дэлгэц, урсдаг гэрэлт самбараар өдөр тутмын мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна.</p>  <p>3. Төвийн зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг үйлчлүүлэгчдэд ойлгомжтойгоор байршуулсан.</p>	
	<p>7. Чанарын олон улсын удирдлагын тогтолцооны сайн туршлага судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>3 сайн туршлага нэвтрүүлж ажилласан.</p>	<p>3 сайн туршлага нэвтрүүлж ажилласан байна.</p>	<p>I-IV улирал</p>	<ul style="list-style-type: none"> • Геронтологийн үндэсний төвийн Нүдний кабинетэд өмнө нь хийгдэж байгаагүй "Meibomian gland expression" буюу (мэйбомийн булчирхайн шахалт, тосны булчирхайн шахалт), нулимсны цэгийг тэлж сэтгэх ажилбарыг шинээр нэвтрүүлэн Collins expressor forceps, punctal dilator багаж ашиглаж тус бүр 6 хүнд хийсэн. • 2025 оны 11 сарын 22-нд "Бөөрний үндэсний 6-р семинарт" ГҮТ-ийн Дотрын их эмч Д.Бямбасүрэн өөрийн хийсэн "Ахмад настны түүдгэнцрийн шүүлтгийн хурд ба насны хамаарал" судалгаагаар оролцон шилдэг илтгэлд шалгарсан. • 2025 оны 11 сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Монгол ангаах ухааны эмнэлэгт Чанарын менежер Ж.Уламбаяр, Уламжлалтын эмч Ц.Баярмаа, сувилагч Б.Нарангэрэл нар 2 өдрийн сургалтад хамрагдаж, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж сайн туршлага судласан. 	<p>69%</p>

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 1.2.3.1	8. ОУ-н эмнэлзүйн платформын ашиглалтыг нэмэгдүүлж, хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийнэ.	Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүүдийн 95 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүүдийн 95.1 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	ЭМТҮЧАБ -ыг сайжруулах, нотолгоонд суурилсан анагаах ухааны оношилгоо, эмчилгээнд ашиглах UpToDate цахим платформыг ашиглах цахим сургалтад төвийн нийт 23 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан. UpToDate цахим платформын ашиглалтад 2 удаа хяналт үнэлгээ хийсэн. Нийт 11 эмч, 8 сувилагч ашиглахаас 10 эмч буюу 90%, 8 сувилагч буюу 100% ашиглаж байна. Дунджаар эмч сувилагчдын 95% нь ашиглаж байна.	100%
Зорилт 6. Ахмад настны тусламж, үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлнэ.						
БСТ 1.2.4.1	9. Төвийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн хүчин чадал, нэр төрлийг нэмэгдүүлнэ.	I-I	Хэт авиан оношилгооны суурин аппарат, оношилгоо, эмчилгээндээ нэвтрүүлсэн байна.	III улирал	2025 оны худалдан авалтаар 105.0 сая төгрөгийн өртөг бүхий Хятад улсад үйлдвэрлэгдсэн Mindguy компани COMSONA N6 маркийн хэт авиан оношилгооны суурин аппарат нэг ширхэгийг худалдан авч эмчилгээ оношилгоонд ашиглаж байна. 	100%
БСТ	10. Эмнэлзүйн (гематологийн,	I-I	Биохимийн болон иммунологийн,	III улирал	Энэхүү дүрс оношилгооны аппарат ашиглалтад орсноос хойш нийтдээ 1401 хүнд оношилгоо хийгдсэнээс шинээр бүртгэгдсэн 13 өвчлөл бүртгэгдэж дараагийн шатлал руу онош тодруулахаар явуулсан байна. 2022 онд ЭМЯ хөрөнгө оруулалтаар 51.2 сая төгрөгийн эмнэлзүйн (гематологийн, биохимийн, иммунологийн,	100%


Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
1.2.4.2	Биохимийн, иммунологийн, бактериологийн, шээсний анализатор) лабораторийн аппаратаар хангана.		Бактериологийн лабораторийн аппаратаар хангасан байна.		Бактериологийн, шээсний анализатор) лабораторийн аппаратуудыг нийлүүлсэн шинэ эмнэлэгт орвол ашиглахад бэлэн байна. Өнөөдрийн байдлаар "Манчим" ХХК - тай лабораторийн оношилгоо, шинжилгээний тусламж үйлчилгээг нэг жилийн хугацаатай гэрээгээр гүйцэтгүүлэн ажиллаж байна.	
Зорилт 7. Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, мэргэшил, арга зүйгээр хангана.						
БСТ 2.1.1.2	11. "Настан судлалын эмч", "Настны сувилахуйн" мэргэшүүлэх сургалт зохион байгуулна.	2024 онд Настны эмч 2, настны сувиллагч 3-ыг бэлтгэсэн.	Нийслэлд 3, орон нутагт 3 настны эмч, сувиллагч 2 нийт 8 мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.	I-IV улирал	2025 оны хавар, намрын "Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалт" -д нийт 11 эмч, 2 сувилагч элсэн суралцсанаас: <ul style="list-style-type: none"> Хаврын элсэлтэд "Настан судлал" -аар нийт 6 эмч /Нийслэлээс 5, Орон нутаг 1 эмч/ элсэн суралцаж амжилттай төгссөн. "Настны сувилахуй" -аар Орон нутгаас 2 сувилагч элсэн суралцаж амжилттай төгссөн. Намрын элсэлтэд Баянхонгор, Булган, Говь-Алтай аймгаас нийт 3 эмч, Нийслэлээс 2 эмч элсэн суралцаж байна. 	100%
БСТ 2.1.1.1	12. Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө 2023-2026 хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт 93 хувь биелсэн байна.	Хэрэгжилт 94 хувь биелсэн байна.	I-IV улирал	Геронтологийн үндэсний төв нь Хүний нөөцийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2022-2026 оны хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүний нөөцийн хөгжлийн стратеги төлөвлөгөө нь стратегийн 7 зорилтын хүрээнд 21 бүлэг, зүйлээс бүрдсэн төлөвлөгөөг батлуулж ажилласан ба төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна. Шинэ эмнэлэг ашиглалтад ороогүйгээс шинэ эмнэлгийн үйл ажилгаанд нийцсэн журам боловсруулагдаагүй, шинэ эмнэлгийн хүний нөөцийн хангалт хийгдээгүй байна.	95%
БСТ 2.1.1.3	13. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд настны эрүүл мэндийн чиглэлээр сэдэвчилсэн багц цагийн сургалт зохион байгуулна.	Нийслэлд 2 удаа 150 мэргэжилтэн, Хэнтий, Дорнод, аймагт 160, эмч мэргэжилтэн хамруулсан байна.	Нийслэлд 2 удаа 150 мэргэжилтэн, 2 аймагт орон нутагт танхимаар 160, эмч мэргэжилтэн, цахим сургалтад 160 эмч мэргэжилтнийг тус	I-IV улирал	Геронтологийн үндэсний төвийн захирлын 2025 оны А/20, А/29, А/79 дүгээр тушаалуудаар "Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ" сэдэвт сургалтыг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг батлуулан, 2025 оны 3-р сард нийслэлд 4 дүгээр сард Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс зэрэг аймгуудад 10-р сард, ДЭМБ -ийн санхүүжилтээр	100%



Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
			тус хамруулсан байна.		<p>Өвөрхангай, Баянхонгор аймгуудад тус тус зохион байгуулж, нийт 1610 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулав.</p> <p>Орон нутгийн санаачлага, санхүүжилтээр "Ахмад настанд үзүүлэх цогц тусламж үйлчилгээ SCORE" сэдэвт сургалтыг Сэлэнгэ аймагт 29 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Хөвсгөл аймагт 125 ажилтныг тус тус хамруулав.</p> 	
БСТ 2.1.1.4	14. Настан судлалын цахим болон танхимын хөтөлбөрийн батлуулж анагаах ухааны сургуулиудын хичээлийн болон өрхийн анагаах ухааны судлах	I-I	Настан судлалын хичээлийн хөтөлбөр боловсруулан батлуулсан байна.	I-IV улирал	<p>1. Настан судлалын цахим болон багц цагийн танхимын сургалтын хөтөлбөр боловсруулан, ЭМХТ-еер батлуулсан. ЭМХТ-ийн HRDS програмд байршуулан, сургалтыг зохион байгуулж байна. HRDS програмд нийт 16 удаагийн багц цагийн сургалтыг зарлан 674 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан бол "Настан судлал" ба "Настны сувилахуй"-н төрөлжсөн мэргэжлийн сургалтыг тус бүр 2 удаа зарлан 11 эмч, 3 сувилагчийг суралцуулж байна.</p> <p>2. Настан судлалын агуулгыг анагаах ухааны сургуулиудын хичээлийн болон өрхийн анагаах ухааны</p>	100%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилгот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
	хичээлийн хөтөлбөрт оруулна.				<p>судлах хичээлийн хөтөлбөрт оруулахаар АШУҮИС-ийн Өрхийн анагаах ухааны тэнхимтэй хамтран судалж байна.</p> 	
БСТ 2.1.1. 5	15. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд настныг хамруулж буй настнуудын байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид ажиллаж буй мэргэжилтэнг мэргэшүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.	Олон нийтийн ололцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний тендерийн магадлан итгэмжлэлийн ажлын хэсэгт мэргэшсэн гериатр эмчийг оруулж, ХХҮЕГ-тэй хамтран ажилласан байна.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төрийн бус байгууллагуудын 25 ажилтнуудын сургасан хувийг сургасан байна.	I-IV улирал	<p>ГБНХЯ-тай хамтран Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төрийн бус байгууллагуудын ажилтнуудыг чадавхижуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сургагч багшаар тус төвийн мэргэжилтэн С.Гантуяа ажиллахаар томилогдон ажиллаж байна. 2025 оны 4,9 дүгээр сард Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Сүхбаатар, Төв аймгийн ахмадын хороо, ахмадын хөгжлийн төв, асрамжийн төвийн ажилтнуудад "Ахмад настны цогц үнэлгээ" сэдэвт сургалт, уулзалт зохион байгуулсан. Нийслэлд Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн ахмадын хороо, ахмадын хөгжлийн төвийн эмч, ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Нийт 20 гаруй ажиглан сургалтанд хамрагдсан. Монголын Ахмадын байгууллагаас зохион байгуулсан улсын ахмадын байгууллагаас зохион байгуулсан асрахуйн сургагч багш бэлтгэх сургалтад ахлах</p>	69%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					сувилагч М.Отгонжаргал, Э.Солонго нарыг хамруулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээг зүүлэх байгууллагын тендер шалгаруулалт удааширнаас эдгээр төвд ажиллах мэргэжилтнүүдийг сургах ажил хойшилж 2026 оны 1-р сард зохион байгуулахаар төлөвлөж байна.	
Зорилт 8. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн тасралтгүй байдал, нийгмийн баталгааг хангана.						
БСТ 2.1.2.1	Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ур чадварын үнэлгээний журмуудыг шинэчлэн боловрсруулж хэрэгжүүлсэн байна.	2023 онд Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ур чадварын үнэлгээний журмыг шинэчлэн боловрсруулж хэрэгжүүлсэн.	Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын үнэлгээний журмуудыг шинэчлэн боловрсруулж хэрэгжүүлсэн байна.	I улирал	- Геронтологийн үндэсний төвийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 25 өдрийн А/14 дүгээр тушаалаар, Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловрсруулсан. "Мөнгөн урамшуулал олгох журам", "Ур чадварын нэмэгдэл олгох журам" -ыг шинэчлэх ажлын хэсэг 2025 оны 12 дугаар сарын 15 -ны өдөр байгуулагдан ажиллаж байна.	89%
БСТ 2.1.2.2	Геронтологи үндэсний төвийн тоотой уялдуулан 2025-2027 оны хүний нөөцийн төлөвлөлтийг хийнэ.	Хүний нөөцийн хангалт 94 хувьтай байна.	Хүний нөөцийн хангалт 96 хувьтай болсон байна.	I, II улирал	ЭМС -ын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн "Геронтологийн үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай" А/321 дүгээр тушаалаар 47 орон тоогоор батлагдсан. Төвийн захирлын 2025 оны 09 сарын 23-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар мэргэжилтний хангалтын хувь 94 хувьтай байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Нийт 44-н эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад мэргэжилтэн, туслах ажилтан ажиллаж байна.	99%
БСТ 2.1.2.1	Байгууллагын ажилтнуудын харилцаа, хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх хэмжээний төлөвлөгөө боловрсруулж хэрэгжүүлнэ.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн шинэчлэн батлагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт хувьтай байна. Ёс зүйн зөрчил гараагүй	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай болсон байна. Ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан байна.	I-IV улирал	Геронтологийн үндэсний төвийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5-н зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулан ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна. 2025 онд ёс зүйн зөрчлөөс сэргийлэх чиглэлээр дотоодын 8 сургалтыг зохион байгуулсан. Үүнд: 1. "Эмч мэргэжилтний ёс зүй, эмч эмнэлгийн ажилтны харилцаа, эмч үйлчлүүлэгчийн харилцаа, хандлага, хэм хэмжээ" 2. "Ёс зүйн хандлага"	100%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					<p>3. "Ёс зүйн хууль тогтоомж" -ийн талаар 4. "Байгууллагын соёл ба хувь хүний хандлага" 5. "Авилга гэж юу вэ?, түүнээс урьдчилан сэргийлэх нь" 6. "Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эерэг хандлагыг түгээх, Өөрчлөлт хэрэгтэй юу?" 7. "Үе хоорондын ялгаа" 8. Хамт олны харилцаа""Эго ба би" зэрэг сэдэвт сургалтууд зохион байгуулсан.</p> <p>Давхардсан тоогоор 240 ажилтан хамрагдсан. Мөн "Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд бидний оролцоо" болон "Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье" 2 аяныг зохион байгуулсан. Уг аяны үйл ажиллагаанд төвийн нийт ажилтнууд идэвхтэй хамрагдсан ба үндсэн цалингийн 30-50 хувиар шагнаж урамшуулсан.</p> <p>Ёс зүйг сурталчлан таниулах ажлын хүрээнд: Цахим хуудсанд "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм" байршуулсан. Сошиал орчин буюу пэйж хуудсанд ёс зүйн холбогдолтой постер - 11, видео шторк - 3, видео контент - 6, рийлс - 6 тус тус байршуулсан. Ёс зүйн салбар хороонд нийт 4 өргөдөл ирснийг эвлэрүүлэн зуучилсан. Оны хагас жилээс хойш салбар хороонд өргөдөл гомдол ирээгүй байна. Ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх ажил, 2 удаагийн нөлөөллийн аян зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн гэж үзэж байна.</p>	
Зорилт 9. Ахмад настны амьдралын чанарын судалгаа хийж, Эрүүл насжилтийг дэмжинэ. БСТ 2.2.1. 1	Геронтологи, гериатрийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.	"Эрүүл насжилтыг дэмжихүй" ЭШХ-ыг АШУИС-ын НЭМС-тай хамтран зохион байгуулсан.	Геронтологийн Үндэсний төвийн 20 жилийн ойд зориулсан ЭШ, онол практикийн хурлыг зохион байгуулсан байна.	IV улирал	2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр "Эрүүл, идэвхитэй насжилт -2025" сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд АШУИС, АУС, ГҮТ-ийн Эрдмийн зөвлөл, Насжилт, настны эмгэг судлалын нийгэмлэг, Нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төвийн гериатр эмч, эрдэмтэн судлаачид оролцлоо.	100%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 2.2.1.2	28. Настны эрүүл мэнд, нийгэм сэтгэлзүйн байдал үндэсний хэмжээний тойм судалгааг хийнэ.	Ахмэд настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг үнэлэх, нотлогоо бүрдүүлэх чадавхийг үнэлэх судалгаа 2023 онд хийгдсэн.	Судалгааны арга аргачлалыг батлуулсан байна.	I-IV улирал	<p>Эрдмийн бүтээлийн Аман илтгэлийн төрөлд Тэргүүн байранд Б.Норжмаа, Дэд байранд У.Энхбаяр, Гутгаар байанд М.Энхчимэг нар тус тус шалгарлаа. Ханан илтгэлээр Т.Энхсайхан, О.Очгэрэл П.Энх-Учрал нарын илтгэл шалгарлаа.</p> 	49%
БСТ 2.2.1.1	29. Насжилт, настны эрүүл мэнд сэтгүүлийг эрхлэн гаргана.	2024 оны 1 дүгээр улиралд 7 дугаар хэвлэгдэн гарсан.	Сэтгүүл хэвлэгдэж, байгууллагуудад түгээсэн байна.	IV улирал	<p>- ДЭМБ -ийн батлагдсан удирдамжаар Насган хүн амын судалгааг /Global Aging Population Survey/ хийхээр ДЭМБ, Азийн хөгжлийн банкинд төслийн саналыг хүргүүлсэн боловч санхүүжилтын дэмжлэг үзүүлэх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн тул төвийн 2026 оны төсөвт 93 сая 650,000 төгрөг суулгасан.</p> <p>Настны эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн байдлын судалгааны арга аргачлалын төслийг боловсруулж 2025 оны 12 сарын 30-ны өдөр зохион байгуулагдах төвийн дэргэдэх Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.</p> <p>"Насжилт, настны эрүүл мэнд" сэтгүүлийн 2025 оны тусгай дугаарын агуулга:</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны Эрдэм шинжилгээний хуралд шалгарсан 3 - 4 бүтээл; • "Эрүүл, идэвхитэй насжилт" 2025 оны Эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн 20 өгүүлэл; • Ахмадын сарын хүрээнд хэрэгжүүлсэн онцлох ажлууд 	89%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					<p>● Багц цагийн сургалтын мэдээ, мэдээллийг тус тус оруулан бэлтгэсэн.</p> <p>Сэтгүүлд нийт 24 эрдэм шинжилгээний өгүүлэл, зөвлөгөө зөвлөмж, нөлөөллийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг эмхэтгэн 2 бүлэгтэй, 50 хуудас бүхий цахим сэтгүүл гаргахаар эх бэлтгэлийг хийсэн.</p> <p>Хэмнэлтийн хуулиар ном, сэтгүүл хэвлэх зардлыг санхүүжүүлэх боломжгүй болсон тул хэвлэгдээгүй.</p>  <p>Geriatrics and Gerontology НАСЖИВТ, НАСТНЫ ЭМГЭГ СУДЛАЛ</p> 	
БСТ 3.1.1. 3	30. Геронтологи, гериатрийн чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, сургалтад оролцоно.	БНСУ-ын улсын туршлага судалсан.	2-3 олон улсын семинар, сургалт, хуралд оролцсон байна.	I-IV улирал	<ol style="list-style-type: none"> 1. Дэд захирал М.Энхбаяр нь Япон улсад ахмад настны чиглэлээр хурал, семинарт оролцсон. 2. ЭШСА-ны мэргэжилтэн С.Гантуяа Хонг-Конг улсад 2025 оны 5-р сарын 28-31-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Healthy ageing 2025" Ахмад настны цогц туламж, үйлчилгээг хэрэгжүүлж буй Монгол улсын туршлагыг танилцуулж, ICORE-ийн шинэчилсэн сургалтад суралцсан. 	100%
Зорилт 10. Байгууллагын хөгжил, бүтэц, зохион байгуулалтын оновчтойг тогтолцоог бүрдүүлнэ.						
БСТ	31. Байгууллагын удирдлага, бүтэц,	I-I	Төвийн эмнэлгийн шинэ бүтэц,	I-IV улирал	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 08 сарын 02 ний өдрийн а/297 тоот 2025 оны "Төсвийн хуваарийг	100%

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					<p>2. Журмын хэрэгжилтэд 2 удаагийн хяналтыг хийж арга зүйгээр хангаж ажилласан Нийт 29 эмч, мэргэжилтэнг хамруулсан.</p> <p>3. 2025 оны 10-р сарын 29-ний өдөр батлагдсан удирдамжийн дагуу Геронтологийн үндэсний төвийн мэдээллийн технологийн өнөөгийн байдлын үнэлгээ хийсэн.</p> <p>Барилга байгууламжийн эрсдэл :</p> <ul style="list-style-type: none"> - Байшин, барилгын биет хамгаалалт сул - Цахилгааны шит хамгаалалтгүй - Эмчилгээний зарим өрөө тогны залгуурууд газардуулгагүй - Сүлжээний зураглал байхгүй, стандарт бус сүлжээний сувагчлалтай гэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн. <p>Эрсдлийг бууруулах зорилгоор газардуулгатай залгуурыг шаардлагатай зарим өрөөнд байршуулсан. Сүлжээний зураглалыг гаргасан. Сүлжээг сайжруулахад шаардлагатай ажлын тооцооллыг гаргасан 2026 оны байгууллагын төлөвлөгөөнд тусгахаар шийдвэрлэсэн.</p> <p>4. Серверийн өрөөний стандарт / MNS ISO/IEC 27005:2025/ зөрчигдсөн:</p> <ul style="list-style-type: none"> - өрөөний чийгшлэл тэнцвэржүүлэгчгүй - дулаан мэдрэгчгүй - дохиоллын системгүй - нэвтрэлтийн дижитал системгүй - зориулалтын тааз ханагүй зэрэг зөрчлүүд илэрсэн. Энэхүү зөрчлийг арилгахын тулд серверийн өрөөг шинэчлэхэд шаардлагатай тооцооллыг 2026 оны байгууллагын төлөвлөгөөнд тусгахаар шийдвэрлэсэн. - Мөн Firewall хамгаалалтын төхөөрөмж суурилуулах шаардлагатай байна. - Файл серверийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулж, илэрсэн техникийн алдаа 	

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
					<p>зөрчлүүдийг цаг тухайд нь засварлах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>5. Нийт 1.050.000 төгрөгийн үнэ бүхий 30 хэрэглэгчийн вирусны эсрэг програм хангамжийг /Kaspersky stansard edition/ худалдан авч суурилуулсан.</p> <p>Санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой шилэн дансны мэдээллийг shilendans@mof.gov.mn цахим системд байршуулан ажиллаж байна. Нийт 29 нэр төрлийн 180 мэдээлэл байршуулахаас 178 мэдээллийг хугацааны хоцролгүй, 2 мэдээ хугацаа хоцорч байршуулсан.</p>	95%
Зорилт 11. Төвийн санхүүгийн төлөвлөлтийг шинэчлэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.						
БСТ 3.1.2.1	33. Төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах, хяналт тавьж ажиллана.	Санхүүгийн үйл ажиллагаанд зөрчилтэй дүгнэлт авсан.	Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулж шилэн данс холбогдох мэдээллийг хугацаанд нь, хугацааны хоцролгүй болно.	I-IV улирал		100%
	34. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хасагдал 4 хувь байсан.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хасагдал 3 хувь болсон байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хасагдал 3 хувь болсон байна.	I-IV улирал	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний даатгалын гүйцэтгэлийн чанарын хяналтаар эмнэлзүйн хасалт бүртгэгдээгүй. 2025 онд нийт 443 өвчний түүх хянагдсанаас цахим хасалтын хувь жилийн эцсийн байдлаар 1.3 хувь болж буурсан байна.	
	Хянан, дүгнэн, тохиолдлыг бууруулан ажиллана.					

Д/д	Арга хэмжээ	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн үйл явц	Биелэлтийн хувь
БСТ 3.1.2. 2	35. Байгууллагын санхүүгийн удирдлагыг баримтлан, үр ашигтай хэрэгжүүлж өр, авлагагүй ажиллана.	2024 оны жилийн эцсээр ЭМД-сангаас 158,4 сая төгрөгийн авлагатай. Эндээс шалтгаалан тендерийн худалдан авалтын өглөг 76,0 сая төгрөг байна.	Төвийн төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна.	I-IV улирал	Ямар нэгэн өр, авлага төлбөрийн тооцоогүй ажиллалаа	100%
БСТ 3.1.2. 2	36. Байгууллагын тусламж, үйлчилгээний өртөг тооцож, холбогдох байгууллагад санал хүргүүлж ажиллана.	2025 оны төсвийн төсөлд шинэ эмнэлэгт нэмэгдэх тусламж, үйлчилгээний өртгийн тооцооллыг хийж ЭМЯ-нд хүргүүлсэн.	2026 оны шинэ эмнэлэгт нэмэгдэх тусламж, үйлчилгээний өртгийн тооцооллыг хийж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	II улирал	Одоогийн байдлаар эрүүл мэндийн даатгалын газраас 10 төрлийн 700 оношийн хамааралтай бүлгээр ангилан нэг өвчтөнд ноогдох өртгийн жинг тооцон санхүүжилт олгож байна. Манай байгууллагын хувьд шинэ эмнэлэгт орох үед одоогийн үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх боловч шинээр өртгийн тооцоолол хийж санал оруулах эмнэлгийн тусламж үйлчилгээ байхгүй байна.	0%

ЗАХИРЛЫН АЛБАН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.БАТ-УНДРАХ

ХЯМАСАН:

ЗАХИРГАА ТӨЛӨВЛӨЛТ, СУРГАЛТ ХӨГЖЛИЙН
АЛБАНЫ ДАРГА Н.ДОЛГОРМАА
БОЛОВСРУУЛСАН:

СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Л.ХАЛИУН